

“ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ”-ЫН УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Оюутнуудын судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх, оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, онол практикийн мэдлэгийг нь гүнзгийрүүлэхэд энэхүү эрдэм шинжилгээний хурлын зорилго оршино.

1.2 Банк санхүү, бичил санхүүгийн зах зээл сонирхон судалж, энэхүү зах зээл дээр цаашид урт хугацаанд ажиллах сонирхолтой оюутан залуучууд нээлттэй оролцох боломжтой.

Хоёр. Эрдэм шинжилгээний бага хуралд тавих илтгэлийн сэдвүүд

2.1 Монголын бичил санхүүгийн салбар, тулгамдаж байгаа асуудлууд, шийдвэрлэх арга зам, хүлээгдэж байгаа үр дүнгийн асуудлыг хөндсөн, түүнийг шийдвэрлэх арга замуудыг тодорхойлсон байна.

- ✎ Бичил санхүүгийн зах зээл дэх зохицуулалтын хүрээний хууль эрх зүйн орчин, түүнийг боловсронгуй болгох шаардлага
- ✎ Бичил санхүүгийн байгууллагуудын ядуу болон бага орлоготой иргэдэд үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлэх шинэлэг арга замууд
- ✎ Олон улсын бичил санхүүгийн зах зээлийн хөгжил болон Монгол улсын бичил санхүүгийн хөгжлийн түвшин /харьцуулсан судалгаанд үндэслэх/, цаашдын чиг хандлага
- ✎ Санхүүгийн зах зээл дэх ББСБ-ын гүйцэтгэх үүрэг, ач холбогдол, цаашдын чиг хандлага
- ✎ Санхүүгийн зах зээл дэх шинэ санхүүгийн хэрэгсэл, түүнийг хэрэгжүүлэх нь
- ✎ ББСБ-ын банкнаас ялгагдах онцлог ба нийгмийн ач холбогдол
- ✎ Бичил санхүүгийн үйл ажиллагаанд цахим төлбөр тооцооны хэрэгслийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх арга зам
- ✎ Бичил санхүүгийн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, олон улсын туршлага, арга замууд
- ✎ Биет бус хөрөнгийг зээлийн барьцаанд ашиглах боломж
- ✎ Бичил санхүү-жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжлийн хөшүүрэг
- ✎ Факторингийн үйлчилгээ, түүнийг эрдэлийг бууруулах хүчин зүйлс
- ✎ Бичил санхүүгийн зах зээлийн хөгжилд бичил даатгалын гүйцэтгэх үүрэг
- ✎ ББСБ-д нэвтрүүлэх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний судалгаа
- ✎ Банк бус санхүүгийн байгууллагын маркетингийн онцлог
- ✎ Зээлийн хүүг тооцох аргачлал, боловсронгуй болгох нь
- ✎ Зээлийн эрсдэлийн үнэлгээний загвар, аргачлал
- ✎ Зээлдэгчид рейтинг тогтоох аргачлал, түүнийг дотоодын зах зээлд хэрэгжүүлэх боломж
- ✎ Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний судалгаа, хэрэгжүүлэх боломж, шинэлэг санаа
- ✎ Бичил санхүүгийн салбарт IPO хийх аргачлал болон олон улсын туршлага
- ✎ Банк бус санхүүгийн байгууллагын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх боломж

Гурав. Илтгэлд тавигдах шаардлага

3.1 Агуулгын хувьд ерөнхий шаардлага:

- Эдийн засаг, санхүү, менежментийн шинжлэх ухааны тодорхой онол арга зүйн үндэслэлтэй байна,
- Бодит байдалд хэрэгжиж болохуйц, шинэлэг санаа дэвшүүлсэн,
- Бодит мэдээлэл ашиглаж, баримт материал хавсаргаж баталгаажуулсан,
- Судалгаа, шинжилгээний тодорхой арга хэрэгслүүдийг ашигласан байна,
- Ишлэл зүүлтийн заалт бичих,
- Ашигласан ном, судалгааны ажил, материалын жагсаалт бичих,
- Удиртгал, илтгэлийн агуулга, ерөнхий дүгнэлт, зөвлөмжийг заавал хийнэ.

3.2 Илтгэлийг боловсруулахад тавигдах ерөнхий шаардлага:

- Илтгэлийг А4 цаасанд дээр дараах форматын дагуу бичнэ,
 - Үсгийн фонд : Tahoma
 - Үсгийн хэмжээ : 10
 - Мөр хоорондын зай : 1.5
 - Хүрээ : Normal
- Илтгэлийн хуудасны тоо 20-40 байна,
- Нүүр хуудсанд сургууль, мэргэжил, курс, овог нэр, сэдвийн нэр, он бичсэн байна,
- Нүхэлдэггүй нуруутай хавтсанд хийнэ,

Дөрөв. Илтгэгч оюутанд тавих шаардлага

- 4.1 Илтгэлээ хураалгахдаа 1 хувь бүтэн, 1 хувь хураангуй цаасан хэлбэрээр хэвлэсэн байх,
- 4.2 Танилцуулгыг Power Point дээр бичиж 8 минутанд багтаан танилцуулах байдлаар бэлдэх,
- 4.3 Илтгэл болон танилцуулгыг flash–д бичиж ирэх,
- 4.4 Цээж зураг 1 хувьтай ирэх,

Тав. Илтгэл хүлээн авах хугацаа

5.1 2014 оны 11 дүгээр сарын 21-ний 18:00 цаг хүртэл СБД, 1-р хороо, 5-р хороолол 1-17 тоот Экокапитал ББСБ-ын байранд материалыг өөрийн биеэр авч ирж өгнө. Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй. Холбоо барих хаяг болон ЭШХ-ын талаар доорх сайтуудаас мэдээлэл авч болно.

- Утас: 7000-9999, 9910-0138, 99997880
- e-майл: info@ecocapital.mn
- web site: www.ecocapital.mn
- www.facebook.com/ecocapital
- https://twitter.com/#!/Ecocapital_BBCB

Зургаа. Эрдэм шинжилгээний бүтээлийг дүгнэх

6.1 Шүүгчдийн бүрэлдэхүүнд зохион байгуулагч Экокапитал ББСБ-ын ерөнхий захирал, Санхүүгийн зохицуулах хороо, МББСБ-ын холбооны төлөөлөл, МУИС-ЭЗС-ийн багш нар, СЭЗДС-ийн багш нарын төлөөллөөс бүрдэнэ. Дараах байдлаар илтгэлийн агуулгыг шүүнэ. Үүнд:

Шалгуур үзүүлэлтүүд	Хувь	Оноо
Шинэлэг санаа, шийдэл	30%	10
Онол арга зүйн үндэслэл, боловсруулалт	20%	10
Ашигласан материал	10%	10
Дүгнэлт, зөвлөмж	20%	10
Илтгэх ур чадвар	20%	10

Жич: Хамгийн олон оюутнаа оролцуулсан багш нарт 200,000 төгрөгний урамшуулал олгож, хамгийн их дэмжигч оюутнуудтай сургуулийн оролцогчдод 5 бүхэл оноо нэмж урамшуулна.

Долоо. Шалгаруулалт

7.1 Сургууль тус бүрээс хүлээн авсан илтгэлүүдийг хурлын нэгдсэн комисс уншиж танилцан үнэлгээ өгнө. Үнэлгээ өндөр авсан илтгэлийг дараагийн шатны шалгаруулалтанд оруулах буюу Эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл тавих эрх олгоно.

7.2 Шалгаруулах комиссоос сонгогдсон 15 хүртлэх илтгэлийг 11 дүгээр сарын 28-ны өдөр Чингис зочид буудалд болох “Оюуны эрэлд” ЭШХ-д хэлэлцүүлэн дараах байдлаар шалгаруулна.

Шагналын сан:

1-р байр - 1 илтгэл / 1,500,000 төгрөг, өргөмжлөл, бэлэг дурсгалын зүйлс /

2-р байр - 1 илтгэл / 800,000 төгрөг, өргөмжлөл, бэлэг дурсгалын зүйлс /

3-р байр - 1 илтгэл / 300,000 төгрөг, өргөмжлөл, бэлэг дурсгалын зүйлс /

Тусгай байр - 1 илтгэл /100,000 өргөмжлөл, бэлэг дурсгалын зүйлс / тус тус шалгаруулна.

Шалгарсан илтгэгчид болон хуралд амжилттай оролцогчдод МББСБХолбооны гишүүн ББСБ-д дадлага хийлгэх, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, ажил олгох зэрэг нэмэлт урамшуулал олгоно.